



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/323

Есөнбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.13 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 53.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.4 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.9 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 10 дугаар албан даалгавар, Шадар сайдын 2026 оны 3 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэд, олон нийтийн болон орчны аюулгүй байдлыг хангуулах, аюул, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг арилгах, таслан зогсоох, бууруулах үзлэг, хяналт, шалгалтыг 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 06 дугаар сарын 22-ны өдрийн хугацаанд зохион байгуулсугай.

2.Хяналт-шалгалт хийх удирдамжийг нэгдүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сумын төвийн иргэд, олон нийт болон орчны аюулгүй байдал, аюул, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг арилгах, таслан зогсоох, бууруулах үзлэг, хяналт, шалгалтыг зохион байгуулахыг Сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4.Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулсан уул уурхай өрөмдлөгийн цооног, далан, суваг, шуудуу, бичил уурхай эрхлэгчдийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд үзлэг, хяналт, шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Хяналт, шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч нарт үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, үр дүнг нэгтгэн танилцуулахыг Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
... дугаар сарын -ны өдрийн дүгээр
Захирамжийн нэгдүгээр хавсралт

**ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН БОЛОН ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГУУЛАХ, АЮУЛ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ
АРИЛГАХ, ТАСЛАН ЗОГСООХ БУУРУУЛАХ, ҮЗЛЭГ, ХЯНАЛТ- ШАЛГАЛТЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл

1.1. Энэхүү удирдамжийг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 474 дүгээр тогтоолоор батлагдсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам", Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 10 дугаар албан даалгавар болон холбогдох бусад дүрэм, журам, норм, стандартыг мөрдлөг болгоно.

Хоёр. Зорилго

2.1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн түвшинд аливаа болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг арилгах, таслан зогсоох, бууруулах, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангуулах, Монгол хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчныг хамгаалах, аюулгүй амьдрах, ажиллах ээлтэй орчныг бүрдүүлэхэд нэгдсэн удирдамжийн зорилго оршино.

Гурав. Хамрах хүрээ, хугацаа

3.1. Аймаг, сумын Онцгой комисс нь энэхүү үзлэг, хяналт-шалгалтыг эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэн зохион байгуулна.

3.2. Үзлэг, хяналт-шалгалтад засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийг хамруулна.

3.3. Хяналт, шалгалтыг 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 22-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулна.

Дөрөв. Авч хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Аймаг, сумын Онцгой комиссын шийдвэрээр аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна.

4.2. Үзлэг, хяналт-шалгалтын явцад хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хохирол учруулж байгаа буюу учруулж болох аюул, эрсдэл нь зохих ёсоор нотлогдсон, аюул, осол гарч болох тохиолдолд

холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа, нутаг дэвсгэрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн тухайн зөрчлийг арилгах хүртэл хугацаанд хаах, түр зогсоох арга хэмжээг тухай бүр шуурхай авч хэрэгжүүлж, иргэд, олон нийтэд сэрэмжлүүлэг, мэдээллийг тухай бүрт хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэж ажиллана.

Тав. Зардал

5.1.Үзлэг, хяналт-шалгалтыг зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг тухайн сумын Онцгой комисс, хуулийн этгээд хариуцана.

Зургаа. Тайлагнах

6.1.Энэхүү нэгдсэн удирдамжийн хэрэгжилтийн тайланг 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн дотор аймгийн Онцгой комисст танилцуулах.

_ оОо _

Аймгийн Засаг даргын 2026 оны
... дугаар сарын -ны өдрийн дүгээр
Захирамжийн хоёрдугаар хавсралт

**ТӨРИЙН БОЛОН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН
АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Чинзориг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Гишүүд:	С.Содбаяр	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч)
	П.Буянтогтох	(Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх, шуурхай удирдлагын тасгийн дарга, цагдаагийн ахмад)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналтын улсын байцаагч)
	Ц.Бадамгэрэл	(Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч байцаагч) (Гэр бүл, хүүхэд, хөгжил, хамгааллын газрын мэргэжилтэн)
	Ж.Цэрэнсүрэн	(Стандарт, хэмжил зүйн хэлтсийн сургалт, мэдээлэл, стандартын салбар сан хариуцсан мэргэжилтэн)
Нарийн бичиг:	Б.Эрдэнэсүрэн	(Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын хөдөлмөрийн эрүүл ахуйн улсын байцаагч)

**АЙМГИЙН ТОГЛООМЫН ТАЛБАЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД
ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Алтайбаатар	(Гэр бүл, хүүхэд, хөгжил, хамгааллын газрын дарга)
Гишүүд:	Д.Дамдинбазар	(Онцгой байдлын газрын хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч)
	Ш.Батсүх	(Цагдаагийн газрын хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналтын улсын байцаагч)
	Ц.Бадамгэрэл	(хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч)

Нарийн бичиг:	Н.Цээпилмаа	(Гэр бүл, хүүхэд, хөгжил, хамгааллын газрын хүүхдийн эрхийн байцаагч)
	Ж.Цэрэнсүрэн	(Стандарт, хэмжил зүйн хэлтсийн сургалт, мэдээлэл, стандартын салбар сан хариуцсан мэргэжилтэн)
	Д.Нямжаргал	(Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын барилга, хөрөнгө оруулалт, СӨХ хариуцсан мэргэжилтэн)

**АЙМГИЙН ЦЭВЭР, БОХИР, ДУЛААН, ХОЛБООНЫ ШУГАМ
СҮЛЖЭЭНИЙ ХУДАГ, ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ,
ДЭД СТАНЦЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ
АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч:	М.Насанбат	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд:	С.Энхбаяр	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, хошууч)
	П.Буянтогтох	(Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх, шуурхай удирдлагын тасгийн дарга, цагдаагийн ахмад)
	М.Мөнхцэцэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн)
	Х.Биндэрьяа	(“Алтайн улиастайн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ны ерөнхий инженер)
	Б.Бямбачулуун	(“Мандал голомт” ХХК-ны шугамын ашиглалтын инженер)
Нарийн бичиг:	З.Цэвэлмаа	(“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ны ерөнхий инженер)
	Д.Байгальмаа	(“Ундарга-Алтай” ААТҮГ-ын ашиглалтын инженер)

**АЙМГИЙН УУЛ УУРХАЙН ӨРӨМДЛӨГИЙН ЦООНОГ, НӨХӨН
СЭРГЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ
АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Батмагнай	(Байгаль орчны газрын дарга)
Гишүүд:	Т.Баттүвшин	(Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа)
	Д.Эрхэмбаяр	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын геологи, уул уурхайн хяналтын улсын ахлах байцаагч)
	Д.Мөнгөнчимэг	(Байгаль орчны газрын газар газрын хэвлийн ашиглалт хамгаалалт, нөхөн сэргээлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

Б.Төрбат (Цагдаагийн газрын экологийн асуудал
хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч,
цагдаагийн ахлах дэслэгч)

Ц.Бадамгэрэл (Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын
хөдөлмөрийн хяналтын улсын ахлах
байцаагч байцаагч)

Ц.Наранчимэг (Стандарт, хэмжил зүйн хэлтсийн
бүтээгдэхүүн баталгаажуулалтын
мэргэжилтэн)

Нарийн бичиг: Б.Содмаа (Байгаль орчны газрын хүрээлэн буй орчин,
байгалийн нөөцийн хэлтсийн дарга)

_ оОо _